Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
2023 оны ........ дугаар сарын ........-ны
өдрийн ......... дугаар албан бичгийн хавсралт

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

| **Шийдвэр Д/д** | **Заалт Д/д** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар** | **Холбогдох заалтын агуулга** | **Хэрэгжилтын явц** | **Өөрийн үнэлгээ** | **Дээд шатны байгууллын үнэлгээ** | **Үнэлгээний тайлбар** |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 2 | 2 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20 | 7.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөсхамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг | GMP,GHP болон MNS CAC RCP 39:2011 стандартын дагуу зохистой дадлыг мөрдөж ажиллаж байна. 1.Хүнсний түүхий эд,туслах материал - Түүхий эд, туслах материалыг боловсруулалтын шугаманд оруулахын өмнө ялган ангилах, гадны биет болон механик хольцоор бохирлогдсон, муудсан, мэдрэхүйн эрхтний үзүүлэлтийн шаардлага хангахгүй байвал үйлдвэрлэлд хэрэглэхийг хориглох, нийлүүлэгчрүү буцаах, устгах зэргээр асуудлыг шийдвэрлэн ажилладаг. 2.Үйлдвэрлэлийн боловсруулах технологи, шат дамжлага -Чанарын багийн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, түгээх зэрэг хоол, хүнс үйлдвэрлэлийн бүх үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлагыг ханган ажилладаг. 3.Бүртгэл, Баталгаажуулалт - Хүнсний | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэвтрүүлнэ:7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал. | чиглэлийн үйл ажиллагааны төрөл,хэлбэрээс хамааран өөр өөрийн онцлогт тохирсон бүртгэлийг хөтлөн ажилладаг. Үүнд: Эрүүл мэнд ариун цэврийн үзлэгийн бүртгэл, хөргөх төхөөрөмж, хөргөгчний хэмийн бүртгэл, их цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл, дээжийн бүртгэл, хоол хүнсэнд хийгдсэн температурын бүртгэл, өдөрт хийсэн, бэлтгэсэн хоол, хүнс, илүү гарсан хоол, хүнс, түүнийг устгаж хаясан бүртгэл зэргийг мөрдөн ажиллаж байна.<br>4. Ажилтны хувийн ариун цэвэр,эрүүл мэндэд тавих шаардлага -Хувийн ариун цэвэр, гар угаах, бээлий<br>5. Бүтээгдэхүүнийг эргүүлэн татах, дахин боловсруулах,устгах-Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд харъяалах хяналтын байгууллага, нийлүүлэгч болон дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид урьдчилж утсаар, цахим шуудангаар, эцэст нь албан бичгээр мэдээлж хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авч ажилладаг. | | | |
| | 3 | | 10.2. Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл | Эмнэлгийн Хоол шим тэжээлийн тасгийн ажилтнуудыг жилд 2 удаа (6 сар тутам 1 удаа) Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /10.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/; | | | | |
| 3 | 4 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01 | 11.2.. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам | Эмнэлгийн хэмжээнд нийт 7 жолооч ажиллаж байна. Жил бүр эмнэлгийн ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагддаг. Монгол улсын стандарт MNS 6717:2008 Түргэн тусламжийн төвийн бүтэц үйл ажиллагааны 4.4 заасны дагуу ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/294 тоот тушаалд заасан түргэн тусламжийн эм тарианы жагсаалтын дагуу яаралтай тусламжийн цүнхэнд эм тарианы бэлэн байдлыг хангасан. Бүх машин Зөөврийн каталк, универсал чиг, хүзүүний чиг, хүчилтөрөгчийн баллон, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | хөнжил гудсаар хангагдсан. 2 машин бүрэн тоноглогдсон монитортой. Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэхдээ 2 монитортой машин явдаг. | | | |
| 8 | 15 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2022 оны "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тайлан"-г 2022 оны 12 дугаар сарын 15-нд эрүүл мэндийн яамд, "ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-ний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 15-нд эрүүл мэндийн яамд, 2023 оны 1 дүгээр сарын 11-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн. | 100 | | |
| | 30 | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 | 7.1.4.. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй | 2022 оны 01 дүгээр сараас 3 дугаар сар хүртэл Коронавируст халдвар (КОВИД-19)-тай хүндэвтэр, хүнд, нэн хүнд өвчтөнийг эмчлэх тасгуудад нийт 73 (давхардсан тоогоор) эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад тусгаалах бүсэд орохоос өмнө чиглүүлэх сургалтыг дараах чиглэлээр Захиргаа хүний нөөцийн алба, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, Халдвар хяналтын алба болон Сувилахуйн алба хамтран дараах чиглэлээр зохион байгуулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2020.04.29 | байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | 1. Тусгаарлан эмчлэх тасгийн бүтэц, зохион байгуулалт<br>2. Тусгаарлагдан ажиллах заавар<br>3. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах дадлага сургалт<br>4. Оношилгоо, эмчилгээ | | | |
| | 32 | | 7.1.11.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан эрүүл мэндийн яам, халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн гэсэн эрүүл мэндийн байгууллагаас ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зөвлөмж мэдээллийг цаг тухай бүрт нийтлэн цааш түгээн ажилласан. Нийт 17 төрлийн постер, 8 төрлийн шторк видеог цахим хуудсаар дамжуулан түгээсэн байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 35 | | 7.1.15.. цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ | ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН IX ЖАГСААЛТ, ХҮҮХДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН II ЖАГСААЛТ-д үндэслэсэн манай эмнэлэгийн Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн гаргасан. Мөн VEN ангилалд багтах эмүүдийн жагсаалт, Амин чухал эмийн жагсаалтуудыг шинэчлэн гаргаж, батлуулахаар шатандаа байна. 2022 оны 6 дугаар сарын 20-ны Эрүүл мэндийн яамны 5/2958 тоот албан бичгийн дагуу олон улс болон хөрш орнуудад КОВИД-19-ийн халдварын тохиолдол буурахгүй, шинэ хувилбар гарах магадлал өндөр байгаагаас эмийн хангамж, нийлүүлэлтэд хүндрэл тулгарч, тасалдал үүсэх эрсэдэлтэй тул 2-с доошгүй сарын нөөц бүрдүүлэн, эрсдлээс сэргийлэн ажиллах зөвлөмж өгсөн. Үүний дагуу эхлээд Амин чухал эмийн жагсаалтын дагуу нөөц үүсгэн ажиллаж байна. | 100 | | |
| | 36 | | 7.1.16.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдвараар өвдсөн нийт 289 ажилтанд өвдсөн хугацааны үндсэн цалин буюу 75,828,292 төгрөгийн цалин хөлсийг олгосон. (Ерөнхий захирлын Б/45, Б/84)<br><br>- 2022 оны 01 дүгээр сараас 3 дугаар сар хүртэл Коронавируст халдвар (КОВИД-19)-тай хүндэвтэр, хүнд, нэн хүнд өвчтөнийг эмчлэх тасгуудад ажлын тусгай горимоор томилогдон ажилласан нийт 73 (давхардсан тоогоор) эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын 7177 цагийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | илүү цагийн хөлс 14,245,706 төгрөгийг тооцон олгосон. (Ерөнхий захирлын 2022 оны Б/46, Б/85) | | | |
| | 37 | | 7.1.17. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ | Эмнэлгийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын цэгийн үйл ажиллагаа 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн нийт 68,645 хүн/тун дархлаажуулалт хийсэн байна. 1-р тунд 24,669, 2-р тунд 24,697 3-р тунд 17,885 4-р тунд 1,392 хүнийг дархлаажуулсан. | 100 | | |
| | 38 | | 7.1.21.. коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох харьцаа хандлагатай холбоотой гомдол Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд бичгээр болон амаар бүртгэгдээгүй. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 40 | | 7.1.23.. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | Эмнэлгийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын цэгийн үйл ажиллагаа 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн нийт 68,645 хүн/тун дархлаажуулалт хийсэн байна. 1-р тунд 24,669, 2-р тунд 24,697 3-р тунд 17,885 4-р тунд 1,392 хүнийг дархлаажуулсан. | 100 | | |
| | 42 | | 9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Коронавируст (COVID -19) халдварын цар тахлын үеийн эрүүл мэндийн<br><br>тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахтай холбоотой ЭМСайдын баталсан журмын дагуу тухай бүр ажиллаж, эмнэлэгт мөрдөх түр зааврыг нийт 17 удаа шинэчлэн боловсруулж нийт ажилчдад мэдээлсэн | 100 | | |
| | 43 | | 9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах | КОВИД-19 цар тахлын үед нөөцлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн жагсаалт, нөөц бүрдүүлсэн мэдээг долоо хоног бүрийн 1,3,5 дах өдрүүдэд Эрүүл мэндийн яамны BURTGEL.MOHS.MN -д гаргаж өгч байна. Нөөцийн жагсаалтад орсон 52 нэр | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | төрлийн эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээг гарган ажиллаж байна. | | | |
| | 44 | | 9.4. Халдварт өвчнөөс хамгаалах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эмнэлгийн хэрэгсэл хангах нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага улсын хилээр оруулах бөгөөд хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний | Манай эмнэлгийн лаборатори эмнэлгийн хэрэгслийг шаардлага хангасан эсэхийг тодорхойлох лабораторийн шинжилгээг хийдэггүй. Харин тендерээр нийлүүлэх нэг удаагийн хамгаалах хэрэгсэл зэргийг чанар хангасан эсэхийг тендерийн хорооны гишүүд хянадаг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | | | | |
| 15 | 48 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө зэргийг боловсруулан ажиллаж байна.<br><br>1. Байгууллагын эрхэм зорилго: Монгол улсын иргэдийн эрүүл амьдрах, сэтгэл ханамжийг хангаж ажиллах, үйлчлүүлэгч болон ажилчдын орчны аюулгүй байдлыг хангасан, үйлчлүүлэгч төвтэй цогц үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна.<br><br>2. А. Үйл ажиллагааны стратегийн зорилго: Олон улсын стандартад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээтэй холбоотой стандартуудыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн батламж авч, Монгол улсын шилдэг эмнэлэг болох, үйлчлүүлэгчдэд Монгол улсын шилдэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэдгээ хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Б. Үйл ажиллагааны стратегийн зорилт: Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллага болох(JCI), гадаадаас үйлчлүүлэгч хүлээн авах, эмнэлгийн гол үйлчилгээг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, эмнэлгийн ажилчдыг олон улсын жишигт нийцүүлэн сургах, мэргэшүүлэх, шаардлага хангасан эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлэх гэсэн 6 гол зорилт тавин ажиллаж байна.<br><br>3. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба түүний үр дүн:<br><br>Байгууллагын өнөөгийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийснээр, эмнэлгийн цаашдын үр өгөөжтэй ажиллах, байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд шинээр ямар арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө гарган ажилласан.<br><br>Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийснээр Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудал нь нийт 61 хууль байна. Үүнээс Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 18 хуулийн хүрээнд | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | салбарын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон.<br><br>SWOT шинжилгээ хийж, дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны эрсдэл, боломжийг дүгнэн шинжилж цаашид хэрэгжүүлэх эрсдэл боломжийн төлөвлөгөөг нарийвчлан тодорхойлсон.<br><br>Салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлж, хүрэх үр дүнг тооцсон бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж цаашдын стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | | | |
| | 49 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цахим хуудас болох http://ssch.gov.mn веб сайтын ил тод байдлын цэс нь: Үйл ажиллагааны ил тод байдал<br>● Төсөв санхүүгийн ил тод байдал<br>● Төлбөр тооцоо<br>● Худалдан авах ажиллагааны ил тод байдал<br>● Хүний нөөцийн ил тод байдал | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ● Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо<br><br>● Авлигын эсрэг үйл ажиллагаа гэсэн дэд цэснээс бүрдэх бөгөөд.<br><br>Эмнэлгийн ерөнхий захирлын тушаалууд, үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллүүд, нээлттэй ажлын байрны зар, шаардлагатай утасны жагсаалтуудыг байрлуулан тогтмол шинэчилдэг.<br><br>Мөн Улсын хоёрдугаар төв эмнэлэг facebook пэйж хуудсанд өдөр тутмын үйл ажиллагаа, шинэ мэдээлэл, ажлын байрны зар гэх мэтчилэн байгууллагатай холбоотой мэдээллүүд 24 цаг тутуамд шинэчлэгдэн орж байдаг. Түүнчлэн 70150222 гэсэн лавлах утас болон 70150206, амбулаторийн 70150210 утсуудаар эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой чанар, аюулгүй байдал, гомдол, санал хүсэлт, талархлыг хүлээн авч, бүх мэдээллээр хангаж ажиллаж байна.<br><br>Санхүү төсвийн тухай хуулийн дагуу https://shilendans.gov.mn/ сайтын Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хуудсанд мэдээллүүдийг тухай бүрд нь оруулж ажилладаг. | | | |
| | 50 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл | Үндэсний аудитын газрын 2021 оны санхүүгийн жилийн аудит хийсэн дүгнэлтээс гарсан зөвлөмжийн дагуу | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | худалдан авах ажиллагааг ил тод, үнэлгээний хорооны гишүүдийг давтагдахгүй байх зорилгоор байгууллагаас Худалдан авах ажиллагааны сургалтанд 2022 онд нийт 10 ажилтан хамруулсан. Улсын төв хоёрдугаар эмнэлгийн 2021 оны гэрээ, гэрээ дүгнэсэн акт, 2022 оны худалдан авах ажиллагааны дагуу байгуулагдсан гэрээг Үндэсний аудитын газар хүргүүлсэн.<br><br>2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн хүрээнд 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 5/637, 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 5/921 тоот албан бичгээр 2022 оны 46/А0150054 тоот төлбөрийн акт, 249/А0150054 тоот, 251/А0150054 тоот албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Эрүүл мэндийн яам болон Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br><br>Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын 2022 оны төлөвлөгөөний дагуу цөмийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаа, өндөр өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах үйл ажиллагаа болон дотоод аудитын зөвлөмжийн хүрээнд Ерөнхий захирлын 2 албан даалгавар , Ерөнхий захирлын албан даалгаврын хэрэгжилтийн 1 үнэлгээг хийж гүйцэтгэсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 51 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын 2023 оны төлөвлөгөөнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлыг тусгаж, ажлын хэсэг томилон удирдамж, төлөвлөгөөг батлуулан ажиллахаар төлөвлөсөн. | | | |
| | 52 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын хоёрдугаар төв эмнэлэг төлөвлөгөө гаргаж баталсан.<br><br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт арван тайлан хийхээр төлөвлөгдсөн. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2022 оны жилийн эцэст дараах тайлангуудыг хугацаанд нь илгээсэн.Үүнд:<br><br>1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” тайланг 2022 оны 11-р сарын 18-ны өдрийн 1/1112 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>2. Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-ийн тайланг 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 3/1106 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br><br>3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 3/1107 тоот албан бичгээр | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайланг 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 3/1112 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яамны бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. | | | |
| | 53 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | 1995-2021 онд батлагдсан хүчин төгөлдөр 43 хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 28 тогтоол, Эрүүл мэндийн сайд болон ТЕГ-ын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, генералтай хамтарсан тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 122-р тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/94, А/193-р тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/142, А/47-р тушаал, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 116/А565-р тушаал, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮС-ын 2022 оны хамтарсан А/255 А/137 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49/118 дугаар тушаал зэрэг хамтарсан 7 тушаал, Эрүүл мэндийн сайдын 127 тушаал, холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 54 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн албан тушаалтнуудын мэдээллийг цахим хуудсанд http://test9.modiw.mn/pages/hr -д байршуулсан. | 100 | | |
| | 55 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд үйлчлүүлэгчид болон эмнэлгийн ажилтнуудаас ирсэн өргөдөл, гомдол, саналыг “Тусламж үйлчилгээний талаар гаргасан өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх тухай УХТЭ-БМ-02 ТҮЖ 1:2018-3” журмын дагуу бүртгэж, шийдвэрлэж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/50 дугаар тушаалын дагуу улирал бүр Эрүүл мэндийн яамд мэдээллэсэн. 2022 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албад нийт 190 өргөдөл, гомдол, санал хүсэлт бүртгэгдсэн ба 184 гаруй талархал ирсэн байна. Үүнээс бичгээр 104, амаар буюу биечлэн ирсэн 10, утсаар 5, Засгийн газрын 11-11 төвд 81 гомдол, санал ирсэн. Талархалын хуудсаар 150, Засгийн газрын 11-11 төвд 26 талархал тус тус ирсэн. Эдгээр 177 өргөдөл, гомдол, санал нь бүгд үйлчлүүлэгчдээс ирсэн байна.<br>1. Эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 18 өргөдөл, | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гомдол ирсэн ба энэ нь нийт өргөдөл гомдлын 9.4% эзэлж байна. 4 гомдлыг эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба эмнэлзүй хариуцсан дэд захирал, холбогдох тасгийн ажилтнуудыг оролцуулан ноцтой тохиолдол хэлэлцэх хурал хийсэн. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн удирдлагын зөвлөлийн хурлаар дээрх ноцтой тохиолдлыг хэлэлцүүлсэн хурлын явц, хурлаас гарсан шийдвэрийг удирдлагын зөвлөлийн гишүүдэд танилцуулан хэлэлцэж холбогдох тасгийн эрхлэгч, эмч, эмнэлгийн ажилтнуудын хамт удирдлагын зөвлөлөөр дээрх асуудлыг дахин хэлэлцэж тухайн өдөр жижүүрт гарч байсан эмч болон тасгийн эрхлэгч нарт сахилгын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. Холбогдох тасгийн эрхлэгчид 3 сарын хугацаанд ажил сайжруулах төлөвлөгөө гаргаж эмчилгээ эрхэлсэн захирлаар батлуулан ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албыг уг төлөвлөгөөний үйл ажиллагаанд хяналт тавиж ажиллахыг үүрэг болгов.<br><br>2. Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой 45 өргөдөл гомдол ирсэн ба энэ нь нийт өргөдөл гомдлын 23.6% эзэлж байна. Нийт 43 гомдлыг холбогдох тасаг нэгжтэй хамтарч хэлэлцэн шийдвэрлэсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 3. Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой 92 өргөдөл, хүсэлт ирсэн ба энэ нь нийт өргөдөл гомдлын 48% эзэлж байна. Эдгээр өргөдөл хүсэлтийг эмийн эмчилгээг зохицуулах хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. 2022 онд нийт 72 үйлчлүүлэгчид 35,554,944 төгрөгийг буцаан олгосон.<br>4. Бусад 35 өргөдөл гомдол санал ирсэн нь 18% эзэлж байна. Эдгээр 35 гомдлын дийлэнхийг эмнэлгийн гадаах зогсоолын төлбөрийн хураамжтай гомдлууд эзлэх ба тус авто зогсоол нь Улсын Хоёрдугаар төв эмнэлгтэй холбоогүй ба Нийслэлийн авто замын хөгжлийн газар руу тус зогсоолын гэрээг цуцлах тухай албан бичиг удаа дараа хүргүүлж байна.<br>5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 100%. | | | |
| | 56 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | 2022 оны байдлаар:<br>Тус эмнэлэг тайлант хугацаанд ХҮН АМЫН ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ӨВЧЛӨЛИЙН 2022 ОНЫ САРЫН МЭДЭЭ МАЯГТ ЭМТ-501 –аар<br>1.Төрөлт<br>a.Төрсөн эхийн тоо-Бүгд 1<br>b.Амьд төрсөн хүүхэд-Бүгд 1 | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | c.2500 гр-аас доош жинтэй төрсөн хүүхэд 1<br>d.Эхийн тээлтийн хугацаа 22-28 долоо хоногтой<br>2.Нас баралт<br>a.Нас баралт-Бүгд 206<br>b.Хүйсээр<br>i.Эрэгтэй 119<br>ii.Эмэгтэй 87<br>c.Эмнэлэгт нас барсан хүний тоо 206<br>d.Хоног болоогүй нас барсан хүний тоо 47<br>e.Эмнэлэгт 8-24 цагийн дотор нас барсан хүний тоо 20<br>f."1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-Бүгд" 1<br>g.Эхийн эндэгдэл-Бүгд 1<br>h.Нас баралтын шалтгаан<br>i."Хорт хавдарын нас баралт-Бүгд" 25<br>3. Стационар<br>a.Эмнэлэгт хэвтсэн-Бүгд 12921<br>b.Өвчтөн илгээх хуудсаар хэвтсэн хүний тоо 3209 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | c.Эмнэлгээс гарсан, шилжсэн хүний тоо-Бүгд 12656<br>d.Ор хоног-Бүгд /Орны хөдөлгөөнөөр/ 79390<br>4. Амбулторын үзлэг<br>a.Үзлэгийн тоо-Бүгд 155107<br>b.Хүйс<br>i.Эрэгтэй 49775<br>ii.Эмэгтэй 105332<br>c.Үзлэгийн хэлбэр<br>i.Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо 784<br>ii.Амбулаторын үзлэгийн тоо 147166<br>iii.Идэвхтэй хяналт 7156<br>iv.Гэрийн идэвхтэй хяналт 0<br>v.Гэрийн дуудлагын үзлэгийн тоо 1<br>d.Амбулаторийн өвчлөл<br>i.Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл-Бүгд 42848<br>5.Шинэ 35483<br>6.Хуучин 7365<br>ii.Осол гэмтлийн өвчлөл 157<br>iii.Томуу, томуу төст өвчин (J09-J11) 67 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | iv.0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчин (K52.0-K52.9) 43<br><br>v.0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин (J00-J06, J20-J22) 973 тус тус байна | | | |
| | 57 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Олон нийтийн арга хэмжээ бүх төрлийн нээлттэй хөтөлбөрийг тухай бүрт нь цахим хуудсаар дамжуулан мэдээллэж байна. www.ssch.gov.mn | 100 | | |
| | 58 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | ● https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br><br>● Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 132 удаа нийт 48 ажлын байрны зар, эмнэлгийн Facebook хуудас дээр 81 удаа 48 ажлын байрны зарыг байршуулсан<br><br>●Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 3 ажлын байрны захиалга өгсөн.<br><br>●2022 оны 05 дугаар сарын 09-нд 10-12 цагт Этүгэн их сургуулийн сувилахуйн сургуулийн 67 төгсөгчийг “Сувилагч мэргэжлийн бахархал” сэдэвт эмнэлгийн танилцуулга, тойрон аяллыг зохион байгуулсан.<br><br>●Энэрэл дээд сургуулийн “Ажил олгогчийн нээлттэй хаалганы өдөрлөг”-т байгууллагын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | танилцуулга, ажлын байрны зарыг видео шторкыг хүргүүлэн оролцсон.<br>●Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн Н.Дорждэрэмтэй хамтран ажиллаж үйлчлэгч, цахим бүртгэл лавлагааны ажилтны ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах санал, хүсэлтийг хүргүүлсэн.<br>●Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” програмд ажлын байрны зар тогтмол оруулж байна. | | | |
| | 59 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг Эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулж ажилд авч, 2022 онд 119 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. | 100 | | |
| | 60 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Монгол Улсын засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ажилладаг. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны жил бүр төлөвлөгөө боловсруулан | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлж тайланг Эрүүл мэндийн яамны ёс зүйн хороонд хүргүүлдэг. Тайлант хугацаанд эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд гаргасан ёс зүйн зөрчил байхгүй. | | | |
| | 61 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) “Ил тод байдал” хэсгийн “Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулсан. | 100 | | |
| | 62 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) “Ил тод байдал” хэсгийн “Үйл ажиллагааны ил тод байдал” хэсэгт “Эмнэлгийн даргын тушаал”-д 2016 оноос 2022 оны эмнэлгийн удирдлагын тушаалын жагсаалт, 2022 оны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлууд, түүний шийдвэрүүдийг байршуулсан. | 100 | | |
| | 63 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 165,355,960 төгрөг, 2022 оны IV улиралд 501 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 212,025,308 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104, А/155 тушаалууд) | | | |
| | 64 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | 2021 оны төсөв, гүйцэтгэлийн мэдээлэл, 2022 оны төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас /shilendans.gov.mn/ тухай бүр байршуулсан. | 100 | | |
| | 65 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Байгууллагын санхүүгийн 2021 оны болон 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж Эрүүл мэндийн яамаар баталгаажуулсан. | 100 | | |
| | 66 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | 2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтийн хэрэгжилтийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Эрүүл мэндийн яам болон Үндэсний аудитын газарт албан бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 | | |
| | 67 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Улсын төв хоёрдугаар эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг эмнэлгийн захирлын тушаалаар баталгаажуулсанг цахим хуудсанд ил тод байдал цэсийн эмнэлгийн даргын тушаал хэсэгт байршуулсан. | 100 | | |
| | 68 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон авлаг, өглөгийн мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор гарган төрийн сангийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэнээр хянуулан баталгаажуулж шилэн дансанд байршуулан ажилласан. | | | |
| | 69 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын ажил үйлчилгээний нэр, гүйцэтгэгчийн нэр гэрээний дүн, санхүүжилтийн хэмжээг өссөн дүнгээр гарган сар бүр шилэн дансны мэдээлэлд цаг хугацаанд нь мэдээлэн тайлагнасан. | 100 | | |
| | 70 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт сар бүр Сангийн яамны шилэн дансны shilendans.gov.mn цахимд мэдээлж ажилласан. Төрийн сангийн харилцах дансаар хийгдсэн холбогдох орлого зардлын гүйлгээг гүйлгээ тус бүрээр батлагдсан маягтын дагуу тухай бүр мэдээллийг оруулсан. | 100 | | |
| | 71 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг Сангийн яамны шилэн дансны shilendans.gov.mn цахимд мэдээлж ажилласан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 72 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтийн талаар аудитын зөвлөмж хүлээж аваагүй. | 100 | | |
| | 73 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны цахим системийг хөтөлж тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж тендерт оролцогчдод сонгон шалгаруулалтын хариу болон мэдэгдэх хуудсыг tender.gov.mn цахим системд нийтлэн хагас жил, бүтэн жилийн тайлан мэдээг /tender.gov.mn/ байршуулсан. | 100 | | |
| | 74 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | 2021 оны худалдан авах ажиллагааны гэрээ, гэрээ дүгнэсэн акт, 2022 оны худалдан авах ажиллагааны хагас болон бүтэн жилийн тайлан, үнэлгээний хорооны гишүүдийн мэдээллийг үндэсний аудитын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | газрын шаардлагын дагуу хүлээлгэн өгч акт үйлдсэн. | | | |
| | 75 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Тендерт оролцогч байгууллагуудын тодруулгад тухай бүр мэдээллийг хүргэж мэргэжил арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан. Тендерийг зохион байгуулах үнэлгээний хорооны нарийн бичиг, гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан. | 100 | | |
| | 76 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Цөмийн оношилгоо эмчилгээний төв, яаралтай тусламжийн тасгуудад олон улсын байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байгаа төсөл хөтөлбөрийн хүрээнд 311,594.2 мянган төгрөгийн санхүүжилттэй үйл ажиллагааг зохих журмын дагуу зарцуулах эрхийг нээлгэн зориулалтын дагуу зарцуулалтад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 204,185.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. | 100 | | |
| | 77 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | 2022 онд судалгаа, шинжилгээний ажил захиалгаар хийгдээгүй. | 100 | | |
| | 78 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч | Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн болон материаллаг хандив тусламжын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | орлого, орлог зарцуулалтын мэдээг сар бүр байршуулан ажилласан. | | | |
| | 79 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг эмнэлгийн захирлын тушаалаар баталгаажуулсныг цахим хуудсанд ил тод байдал цэсийн эмнэлгийн даргын тушаал хэсэгт байршуулсан. | 100 | | |
| | 81 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | ● Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын төсөлд тусгах саналыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 01 дүгээр сарын А/06, 03 дугаар сарын А/29 дүгээр тушаалаар батлагдсан Ажлын хэсгээр санал авч гаргасан саналуудыг эмнэлгийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгасан.<br>● "Содура" консалтинг компаниас авч буй зөвлөх үйлчилгээний хүрээнд эмнэлгийн 2023-2026 оны Стратеги төлөвлөгөөг нийт төв, алба, тасаг, хэсгийн ажилтнуудын санал, удирдах ажилтны оролцоог хангаж боловсруулан 2023 онд батлуулахаар ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 82 | | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | - Паноптик офтальмоскопид зориулсан ухаалаг утасны универсал адаптер (Л.Эрдэнэхүү, Д.Батжаргал, Ө.Цолмон, Т.Булган, А.Ууганбаатар, Г.Баясгалан, Ш.Мягмарсүрэн)<br><br>- Нүдний өмнөд хэсгийн ба нүдний угийн зураглалыг хамтруулан эмнэлзүйд болон судалгаанд ашиглах арга технологи (гарын авлага)-Д.Батжаргал, Ш.Мягмарсүрэн, Г.Төмөр, С.Болд<br><br>- Нүдний өмнөд хэсгийн гадны биет авах шинэ загварын зүүг ашиглах нь (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гарын авлага)-Д.Батжаргал, П.Баясгалан, Г.Баасанбат<br><br>- Нүдний угийн оношилгоонд шинэ цахим арга технологийг нэвтрүүлэх-Г.Баясгалан<br><br>- Зүрхний тосгуурын жирвэгнэл хэм алдагдлын үед цус шингэлэх эмчилгээг Варфаринаар хийх протокол-Б.Золзаяа<br><br>- Зүрх судасны оношилгоо эмчилгээний гарын авлага<br><br>- Зүрхний шигдээсийн менежмент-Т.Байгалмаа<br><br>- Ревматойдный полиартритийн сэдрэлийн үеийн гормоны пульс эмчилгээ-П.Долгормаа<br><br>-УХТЭ-ийн Ангиографийн тасгийн зүрх судасны тасагт хийгдэж буй ажилбарын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өнөөгийн байдал- Л.Эрдэнэхүү, Д.Амарзул, А.Хандаа, Х.Дашдэмбэрэл, Б.Батболд | | | |
| | 83 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | 2022 оны 07 дугаар сарын 01 өдөр Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 20 р хороо Рашаан сувилалын газар гэрчилгээ 40 жилийн хугацаатай гэрчилгээ авсан. | 100 | | |
| | 84 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Гэрчилгээний дугаар: 000010717<br>Нийслэлийн засаг даргын 2015 оны А/902 тоот захирамж<br>Нэгж дугаар: 1330400072<br>Хэмжээ: 46443.0 м.кв<br>Огноо: 2020.01.02<br>Хүчинтэй хугацаа: 5 жил | 100 | | |
| | 87 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Төрийн өмчийг хувь хүн болон хуулийн этгээдэд түрээслэн орлого олдог. Кофе шоп түрээслэгч Ч.Тэрбишээс 11 сарын төлбөр 16,165,200 төгрөг, Мандала органик хүнс ХХК-аас 11 сарын төлбөр 7,816,490 төгрөг, Монос эмийн сангийн Монос Улаанбаатар ХХК-аас 63,662,729 төгрөг, Хас банкны АТМ машины түрээсийн төлбөр 600,000 төгрөг, Хаан банкны АТМ машины түрээсий төлбөр 775,000 төгрөг, Ундааны автомат машин түрээслэгч М Си Эс кока кола ХХК-аас 880,000 төгрөг, Мон-Фарм эмийн сангаас 28,130,000 төгрөг, автомат машин түрээслэгч Мейжик тек Монголиа ХХК-аас 630,000 төгрөг тус тус шилжсэн. Нийт төрийн өмчийг түрээсэлсний орлого 11-р | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сарын 30-ны байдлаар 118,659,419 төгрөгийн орлого олсон байна. | | | |
| | 88 | | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Цөмийн Оношилгоо, Эмчилгээний Төвд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд нь цацрагийн хамгаалалттай ба барилга байгууламжийг цацрагийн алдагдалгүй байхаар зохион байгуулсан. Үүнийг Мэргэжлийн Хяналтын Газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториор хийлгэж цацрагийн хэмжилтийн дүнгээр баталгаажуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Манай төвд орчны цацрагийн хяналтын монитор 7 ширхэг, гарах агаарын урсгалын цацрагийн хяналтын монитор 1 ширхэг, цацрагийн хяналтын зөөврийн багаж 6 ширхэг, хөл гарын цацрагийн бохирдол хэмжигч 1 ширхэг ашиглагдаж байна. Манай төв нь орчны, гарах агаарын урсгал, бохирын гарах урсгалд байнга цацрагийн хяналт хийдэг. Тус төв нь Цөмийн энергийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Барилга хүлээн авах комиссын акт, Мэргэжлийн хяналтын дүгнэлт, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн аюулгүй ажиллагаа, хамгаалалтын хөтөлбөр, цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө зэргийг үндэслэн үйл ажиллагаа явуулж байна | 100 | | |
| | 89 | | 8.6.11. барилга байгууламжийг | 2022 онд Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн цогцос хадгалах байрны барилга | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | байгууламжийг ашиглалтад оруулах комисс тус барилга дээр 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр ажилласан боловч барилгын гүйцэтгэл дутуугаас шалтгаалан хойшлогдсон. | | | |
| | 90 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | www.ssch.gov.mn цахим хуудсанд хязгаарлагдаагүй бүх төрлийн нээлттэй мэдээллийг иргэдэд зориулж тухай бүрт нь шинэчлэн байршуулагдан ажиллаж байна. | 100 | | |
| | 91 | | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Сангийн сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/97/56 тоот хамтарсан тушаалын дагуу Улсын гуравдугаар төв эмнэлэгт “Судсан дотуурх оношилгоо, эмчилгээ”-ний төрөлжсөн мэргэшил олгох сургалтад Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Ангиографийн тасгийн эрхлэгч В. Гантулга хамрагдсаны 1,200,000 төгрөгийн сургалтын зардлыг санхүүжүүлсэн. | 100 | | |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| 18 | 99 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг | 1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд тэдний өвөрмөц хэрэгцээг хангасан харилцааны арга зүйд сургах сургалт, нөлөөллийн ажлыг хийсэн. Тухайлбал байгууллагынхаа дотоод сүлжээнд "Сонсголын бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 | хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | шаттайгаар зохион байгуулах; | зөв харьцах", "Харааны бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн зөв харьцах", "Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн зөв харьцах" гэсэн контентүүдийг байгууллагынхаа бүх эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнд үзүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдлэн ажиллаж байна. | | | |
| | 100 | | 1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах; | 2022 оны 1 сард эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг байгуулагдан зөвлөх эмч 1, эмэгтэйчүүдийн мэс заслын 3 эмч, эмэгтэйчүүдийн кабинетийн сувилагч 1 бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн. 2022 онд 456 өвчтөн хэвтэн эмчлүүлсэнээс 308 өвчтөнд эмэгтэйчүүдийн мэс заслын эмчилгээ хийсэн.<br><br>Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг энэхүү өдөрлөгт тасгийн тусламж үйлчилгээг иргэдэд сурталчилж мөн нөхөн үржихүйн эрүүл мэнд, жирэмсний хяналтын ач холбогдол, БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам зэрэг эрүүл мэндийн боловсрол олгох мэдээллийг хүргэсэн. Нийт 60 ш гарын авлага тарааж, 20 гаруй үйлчлүүлэгч нарт зөвлөгөө мэдээлэл өгсөн. Цахим сүлжээгээр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мөн эмнэлгийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг хүргэж эхэлсэн. Энэхүү эрүүл мэндийн боловсрол олгох цахим зөвлөгөө дугаарт “Умайн хоргүй хавдар эмэгтэйчүүдийн эмгэгийн үе дэх дурангийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 101 | | | мэс засал эмчилгээ” сэдвээр эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч АУ магистр Т.Баярчимэг, АУ магистр клиникийн профессор Я.Дашпагма нар мэдээлэл хүргэв. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн сэдэвт эмчилгээний Live-ийн хандалт нь 2800 хүний үзэлттэй, 84 хүн бусдад цааш түгээсэн /Share/ үзүүлэлттэй байна | | | |
| | 101 | | 1.4/г/. эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцүүлэх. | 1. Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар № /06-83 тоот “УЛСЫН УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ГАДНА ЗАМ ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖИЛ” ажлыг “ЭС ЭМ ЖИ ТИ” ХХК болон “БУМБАТ ДАВАА” ХХК-ийн түншлэл 2021.05.20-2021.08.15 гэрээний хугацаатайгаар доорхи ажлууд хийгдсэн. Үүнд: Явган хүний зам-1598м2 замыг стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг тэмдэглэгээ, эхлэл төгсгөлтэйгээр хийсэн ба гэрэлтүүлэг 10ш шинээр суурилуулсан. Тэргэнцэртэй иргэнд зориулсан стандартын шаардлага хангасан бариул бүхий налуу зам-явган хүний замын 0,2%-д тавигдсан. Эмнэлгийн хэмжээнд нийтдээ 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөтэй. | 100 | | |
| 19 | 102 | Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн | Нэг.1/. хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, | Ковид-19 халдварыг оношлох, эмчлэх, халдварын хяналтанд ашиглах зорилготой түргэвчилсэн ба ПГУ оношлуур, вирусын эсрэг эм тариа, бусад эм эмнэлгийн хэрэгсэлүүд, хувийн хамгаалах хувцас нэг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21 | үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх; (Нэг.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:) | удаагийн хэрэгсэл, амьсгалын аппарат зэргийг ЭМЯ-наас хангасан. | | | |
